



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/261

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 8 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 3 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Эмийн сан, ариутгал, халдваргүйтгэлийн тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Жаргал, эмнэлгийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Бурмаа нарт үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-т даалгасугай.

5. Эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БЯМБАДОРЖ



המשרד לביטחון המדינה

המחלקה לביטחון המדינה



.. המשרד לביטחון המדינה (המחלקה לביטחון המדינה) מודיע כי

המשרד לביטחון המדינה (המחלקה לביטחון המדינה) מודיע כי
המשרד לביטחון המדינה (המחלקה לביטחון המדינה) מודיע כי
המשרד לביטחון המדינה (המחלקה לביטחון המדינה) מודיע כי

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 28 дугаар сарын 26-ны өдрийн
1/261 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	Тизси тизси файмили ХХК /7112153/	Клиник	Нүүр амны өвчний тусламж, үйлчилгээ, согог засал, гажиг засал, мэс засал	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Эдүпарк төв, 1 давхар 112 тоот
2.	Мано грайн ХХК /6619436/	Клиник	Нүүр амны өвчний тусламж, үйлчилгээ, гажиг засал	Чингэлтэй дүүрэг 1р хороо 2р 40 мянгат 18 байр 11 тоот
3.	Стар эрдэнэ дэлгэр ХХК / 7035337/	Клиник	Мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээ	Хан-Уул дүүргийн 11-р хороо, Зайсан Дүнжингарав гудамж, 51а/2 тоот
4.	Элбэг түмэн зоос ХХК /6772447/	Эмийн сан	2-р зэрэглэл	Налайх дүүргийн 2 дугаар хороо, Жаргалант /12190/, Уурхайчдын гудамж, 7 тоот
5.	Ошин фарм ХХК /6539572/	Эмийн сан	2-р зэрэглэл	СХД, 11-р хороо, АОС 3 гудамж, 12Б тоот
6.	ЖЕН фарм ХХК /6178901/	Эмийн сан	2-р зэрэглэл	БЗД, 19-р хороо, цайз, да хүрээ гудамж, 45/2 тоот
7.	Марал сисү мед ХХК /7173545/	Эмийн сан	2-р зэрэглэл	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол /14181/ Алтайн гудамж, 220 байр, 102 тоот.
8.	Ихмайхан уул ХХК /5689414/	Эмийн сан	2-р зэрэглэл	Налайх дүүргийн 8-р хороо 41-30 тоот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 28 дугаар сарын 26-ны өдрийн
1/261 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
ХУУЛИЙН ЭТГЭЭД

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Үйл ажиллагааны чиглэл	Үндэслэл
1	Монос-Улаанбаатар ХХК /2708558/	Эмийн сан ЭСХ-22/22/4468	Эрүүл мэндийн тухай хуулийн 19.20.1 /үйл ажиллагаагаа зогсоосон/
2	Сити фарм мэйк ХХК /6627137/	Эмийн сан ЭСХ-17/22/3469	Зөвшөөрлийн тухай хуулийн зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 /Өөрийн хүсэлтээр/
3	Сити фарм мэйк ХХК /6627137/	Эмийн сан ЭСХ-17/22/3481	Зөвшөөрлийн тухай хуулийн зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 /Өөрийн хүсэлтээр/